



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 01 өдөр

Дугаар 1/298

Мандагговь

“Ажлын байран дээрх сэтгэл зүйн эрүүл
мэнд”-ийн талаар удирдамж, чиглэл батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь заалт, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 2 дугаар бүлгийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.2 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.1.1, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1.2, 2.2.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Албан хаагчдын “Ажлын байран дээрх сэтгэл зүйн эрүүл мэнд”-ийн талаарх удирдамж, чиглэлийг хавсралтаар баталсугай.

2. Удирдамж, чиглэлийн хэрэгжилтэд хяналт тавьж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар, удирдамж, чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг сумдын Засаг даргын Тамгын газар, хэлтэс, агентлагийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Удирдамж, чиглэлийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг бусад төсөл, хөтөлбөртэй уялдуулан зохицуулж, жил бүр төлөвлөгөө гарган баталж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Л.Доржбат)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822111050